

5. ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛИЙН ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨРҮҮД

5.1 Тэргүүлэх чиглэлийн төсөл, хөтөлбөрүүдийн сонголт

Аялал жуулчлалыг хөгжүүлэх үндэсний болон загвар бүс нутгийн ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан бүх төсөл, хөтөлбөрүүдийг дараахь үзүүлэлтүүдээр үнэлэн тэргүүн ээлжийн төслүүдийг сонгон тогтоосон болно. Үүнд:

(Үнэлгээний хүчин зүйлсүүд)

Хугацааны хязгаар: Хойшлуулалгүй яаравчлан шийдэх асуудлууд

А: Нэн тэргүүнд шийдэх ёстой асуудлууд

Б: Нөхцөл байдлаас хамааруулан шийдэх

Шаардлага, хэрэгцээ: Орлуулах боломж

А: Орлуулах ямарч боломжгүй

Б: Бусад арга хэмжээгээр орлуулах боломжтой

Хэрэгжүүлэх боломж: Хэрэгжилтийн цар хүрээ, урсгал болон их засварын зардлыг хэрэгжүүлэхэд хялбар эсэхийг тодорхойлох хэмжүүр болгох

А: Ажлын цар хүрээ, урсгал болон их засварын зардал нь бага, үр өгөөж нь өндөр

Б: Зардал ихтэй, үр ашиг багатай

(Үнэлгээний хэмжүүр)

AAA болон AAB үнэлгээ авсан төсөл хөтөлбөрүүд нь 1, 2 дугаар зэрэглэлд багтсан тул 2005 он гэхэд хэрэгжүүлж дуусах төсөл хөтөлбөрүүдийн тоонд оруулан сонгож авсан болно. Бусад төсөл хөтөлбөрүүдийг 2005– аас 2015 оны хооронд болон 2015 оноос хойшхи хугацаанд хэрэгжүүлэхээр төлөвлөв.

Сонгож авсан тэргүүлэх чиглэлийн төсөл хөтөлбөрүүдийг 5.1 хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 5.1 Тэргүүлэх чиглэлийн төсөл, хөтөлбөрүүд

Тэргүүлэх чиглэлийн төсөл хөтөлбөрүүд	
А ХӨТӨЛБӨРҮҮД	
	<p>1. Засаг захиргааны байгууллагуудыг бэхжүүлэх</p> <p>А-1 Аялал жуулчлалын үндэсний зөвлөлийг тогтмол ажиллуулах</p> <p>А-2 Аялал жуулчлалын газар, Аялал жуулчлалын үндэсний зөвлөлийн хоорондын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах замаар аялал жуулчлалын удирдлагыг бэхжүүлэх</p> <p>А-3 Аймгуудын засаг захиргааны байгууллагуудыг бэхжүүлэх</p> <p>2. Хүний нөөцийг хөгжүүлэх</p> <p>А-4 Аялал жуулчлалын сургалтыг сайжруулах</p> <p>А-5 Байгаль хамгаалагчдын сургалт явуулах</p> <p>3. Эрх зүйн зохицуулалтыг сайжруулах</p> <p>А-6 Аялал жуулчлалын салбар дахь хөрөнгө оруулалтыг хөхүүлэн дэмжих</p> <p>А-7 Газар ашиглалтад тавих хяналтын арга хэмжээнүүд</p> <p>А-8 Лицензийн журам</p> <p>А-9 Аюулгүй байдлыг хангах жишиг</p> <p>4. Хөгжлийн хөтөлбөрүүд</p> <p>А-10 Монголын соёлын өвийг хамгаалах хөтөлбөр</p> <p>А-11 Эртний түүх дурсгалт газруудыг олон нийтэд танилцуулж сурталчлах</p> <p>А-12 Олон улсын агаарын тээврийн үйлчилгээг сайжруулах</p> <p>А-13 Орон нутгийн агаарын тээврийн үйлчилгээг сайжруулах</p> <p>А-14 Төмөр замын үйлчилгээг чанаржуулах</p> <p>А-15 Нүүдэлчдийг хамруулах тогтолцоо</p> <p>А-16 Археологийн болон зэрлэг ан амьтан, ургамлын нөөцийн үндэсний зурагт каталог, газрын зураг</p> <p>А-17 Эко- жуулчлалын мэдээллийн материалыг бүрдүүлэх</p> <p>А-18 Хүрээлэн буй орчны менежментийн нэгдсэн судалгаа</p> <p>А-19 Хилийн чанад дахь маркетинг</p> <p>А-20 Улаанбаатар хотын зочид буудлуудыг хөгжүүлэх ерөнхий чиглэл</p> <p>А-21 Бүс нутгуудаар гэр бааз хөгжүүлэх ерөнхий чиглэл</p> <p>А-22 Улаанбаатар хотын автобусны үйлчилгээний тухай гарын авлага-таннилцуулга</p> <p>А-23 Автобус болон үзвэрийн газруудад хэрэглэхэд тохиромжтой нэгдсэн тасалбар нэвтрүүлэх</p>
Б УЛСЫН ӨМЧИЙН ХҮРЭЭНИЙ ТӨСЛҮҮД	
	<p>1. Соёлын аялал жуулчлалыг өргөжүүлэх</p> <p>Б-1 Богд хааны музейг засч сайжруулах</p> <p>Б-2 Монголын соёлын хүрээлэн</p>

	<p>Б-3 Эрдэнэзуугийн ойр орчмыг тохижуулах Б-4 Хархорины Зочдыг хүлээн авах төв</p> <p>2. Улаанбаатар хотыг жуулчлалын гол төв болгон хөгжүүлэх Б-5 Улаанбаатарт аялал жуулчлалын байнгын зам маршрут тогтоож хөгжүүлэх Б-6 Улаанбаатарт жуулчдад зориулсан гудамж талбай байгуулах Б-7 Улаанбаатарт бэлэг дурсгалын зүйлс болон гар урлалын бүтээгдэхүүний төв байгуулах</p> <p>3. Байгалийн аялал жуулчлалыг хөгжүүлэх Б-8 Тэрэлжийн Зочдыг хүлээн авах төв Б-9 Говь дахь Зочдыг хүлээн авах төв Б-10 Шувууд ажиглах газрыг бэлдэж байгуулах</p> <p>4. Бусад хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээнүүд Б-11 Хархорин чиглэлийн жуулчдын зам Б-12 Улаанбаатар– Хархорин төв автозамыг тэмдэгжүүлэх Б-13 Халуун рашаан, сувиллын газруудыг засч сайжруулах Б-14 Аялал жуулчлалын хувийн секторт зээл олгох тогтолцоо</p>
С	ХУВИЙН ХЭВШЛИЙН ТӨСЛҮҮД
	<p>В-1 Улаанбаатар– Хархорин төв автозамын дагуу алжаал тайлах амралтын газрууд байгуулах В-2 Гэр баазуудын нөхцөл, материаллаг баазыг сайжруулах В-3 Өмнөговийн онгоцны буудлын зурвасыг сайжруулах В-4 Спортын идэвхитэй амралтыг өргөжүүлэх В-5 Морьдын хүрээлэн</p>

Эх сурвалж: ЖАЙКА–гийн Судалгааны баг

5.2 Тэргүүлэх чиглэлийн төсөл, хөтөлбөрүүд

1) Тэргүүлэх чиглэлийн хөтөлбөрүүд

Засаг захиргааны байгууллагуудыг бэхжүүлэх

А.1 Аялал жуулчлалын үндэсний зөвлөл

Аялал жуулчлалыг хөгжүүлэхтэй холбогдсон байгууллагуудыг удирдах зорилгоор Аялал Жуулчлалын Үндэсний Зөвлөлийг Засгийн Газрын 1998 оны 10 дугаар сарын 192 дугаар тогтоолоор дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан байна. Үүнд:

- Дарга: Дэд бүтцийн хөгжлийн сайд
- Орлогч дарга: Байгаль орчныг хамгаалахын сайд

-- Гишүүд: Дэд бүтцийн хөгжлийн яамны төрийн нарийн бичгийн дарга, Сангийн яамны Төсвийн бодлогын газрын дарга, Шинжлэх ухаан, технологи, боловсрол, соёлын яамны Стратегийн менежмент, төлөвлөлтийн газрын дарга, Дэд бүтцийн хөгжлийн яамны Зам тээврийн газрын дарга, Гадаад харилцааны яамны Гадаад худалдаа эдийн засгийн хамтын ажиллагааны газрын орлогч дарга, Монголын аялал жуулчлалын холбооны тэргүүн
-- Нарийн бичгийн дарга: Дэд бүтцийн хөгжлийн яамны Аялал жуулчлалын газрын дарга

А.2 Аялал жуулчлалын газар, Аялал жуулчлалын үндэсний зөвлөлийн хоорондын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах замаар аялал жуулчлалын удирдлагыг бэхжүүлэх

Аялал Жуулчлалын Үндэсний Зөвлөлийг 1998 онд байгуулсантай холбогдон Аялал жуулчлалын Газар нь бодлогын төлөвлөлтийн асуудалд голлон анхаарах шаардлагатай тулгарч байгаа юм. Аялал жуулчлалын газрыг тус яамны Тээврийн газартай нэгтгэн шинэ газар болгон өөрчлөх санал ч мөн хэлэлцэгдэж байгаа болно.

А.3 Аймгийн засаг захиргааны байгууллагын хэмжээнд аялал жуулчлалын удирдлагыг боловсронгуй болгох

Өөрийн харъяаллын нутаг дэвсгэрт аялал жуулчлалыг дэмжих, төвийн захиргааны байгууллагуудтай нягт уялдаатай ажиллаж, аялал жуулчлалын ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан асуудлын хэрэгжилтийг хангах зорилгоор орон нутгийн аялал жуулчлалын удирдлагыг Аймгийн Аялал Жуулчлалын Зөвлөл болон Аялал Жуулчлалын хэлтэс тасгийг байгуулах замаар бэхжүүлж боловсронгуй болгох нь зүйтэй. Бүс нутгуудын (Улаанбаатар хот, Өвөрхангай, Өмнөговь аймаг) тэргүүлэх чиглэлийн төслүүдэд тусгагдсан арга хэмжээг зохион байгуулах ажил нь хуваарийн дагуу 2005 он гэхэд бүрэн биелсэн байх ёстой.

Хүний нөөцийг хөгжүүлэх

А.4 Аялал жуулчлалын сургалтыг сайжруулах

Энэ төслийн үндсэн зорилго нь Худалдаа Үйлдвэрийн Дээд Сургууль болон засгийн газрын харьяа их дээд сургуулиудад багшлах боловсон хүчинг сургаж дадлагажуулах (богино болон урт хугацаагаар гадаадын багш сургагч нарыг урьж ажиллуулах, гадаадад дадлага сургууль хийсэн Монгол багш сургагч нараар хичээл заалгах), сургалтын төрөл бүрийн материалыг бэлтгэх үндсэн дээр цаашдаа аялал жуулчлал, зоогийн газар болон зочид буудлын үйлчилгээний менежмент, хоолны үйлчилгээний менежмент, тогооч үйлчлэгч гэсэн чиглэлээр чадварлаг гүйцэтгэх ажилтан, менежерүүдийг бэлтгэх замаар мэргэжлийн сургалтыг сайжруулах явдал юм. Шинжлэх ухаан, технологи, боловсрол соёлын яамны зөвшөөрлөөр байгуулагдсан Худалдаа үйлдвэрийн дээд сургууль нь мэргэжлийн болон дээд боловсролын сургалтыг нэгтгэсэн үндэсний сургалтын гол дээд сургууль

учраас төслийг хэрэгжүүлэхэд хамгийн зохистой байгууллага мөн гэж үзэж байгаа болно. Төслийг хэрэгжүүлэх явцад олон улсын семинар зохион явуулах болон бусад үйл ажиллагааг авч хэрэгжүүлэх замаар тодорхой үр нөлөө, ахицтай байх үүднээс Аялал жуулчлалын дээд сургууль гэх мэт хувийн салбарын их дээд сургуулиудыг оролцуулсан аялал жуулчлалын чиглэлийн сургуулиудын зөвлөлийг Худалдаа үйлдвэрийн дээд сургууль дээр зохион байгуулах нь чухал. Эрүүлийг хамгаалах, нийгэм хангамжийн яамны харьяалал доор ажиллаж буй аялал жуулчлалын мэргэжлийн сургуулиуд ч гэсэн уг зөвлөлийн гишүүн байвал зохистой.

А. 5 Байгаль хамгаалагчдын сургалт явуулах

НҮБ-ын хөгжлийн программын хүрээнд байгаль хамгаалагчдын гарын авлагыг боловсруулж тараасан байгаа. Гэвч өнөөгийн байдлаар байгаль хамгаалагчид болон улсын байцаагч, ажилтан нарт зориулсан байнгын сургалтын программ үгүйлэгдэж байгаа юм. Ийм учраас улсын байцаагч, байгаль хамгаалагч нарт зориулсан дараахь сургалтын байнгын программуудыг нэн яаралтай боловсруулан хэрэгжүүлэх шаардлагатай байна. Үүнд:

- Гадаадын экспертүүдийг урьж ажиллуулан сургалтын программуудыг боловсруулах
- Сургалтын гол агуулгыг оновчтой тодорхойлох талаар эдгээр мэргэжлийн экспертүүдтэй хамтран ажиллах
- Одоогоор ашиглагдаж байгаа сургалтын гарын авлага, материалуудыг Монголын өнөөгийн нөхцөл байдалд илүү нийцүүлэх үүднээс дахин хянаж үзэх
- Улаанбаатарт сургалтын программуудыг явуулах (жишээлбэл, жилд 2 удаа – аялал жуулчлалын улирлын өмнө болон дараа)
- Жуулчлалын томоохон бүс нутагт (Тэрэлж, Богд хаан, Говь гурван сайханы дархан цаазат газар) дадлага сургалт газар дээр нь явуулах

Эрх зүйн зохицуулалтыг сайжруулах

А. 6 Аялал жуулчлалын салбар дахь хөрөнгө оруулалтыг хөхүүлэн дэмжих

Орлогын татвараас чөлөөлөх буюу бусад арга хэмжээг авч хэрэгжүүлэн аялал жуулчлалын салбарт гадаадын хөрөнгө шууд оруулах үйл ажиллагааг хөхүүлэн дэмжих зорилгоор гадаадын хөрөнгө оруулалтын хуульд зохих нэмэлт өөрчлөлт оруулах нь энэ салбар дахь гадаадын шууд хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх шинэ арга зам мөн. Үүнд:

- Өвлийн улирлын аялал жуулчлалын үйлчилгээг урамшуулах
- Аялал Жуулчлалын Үндэсний Зөвлөлөөс тогтоосон 3- аас дээш одтой зочид буудал, гэр баазууд
- Аялал Жуулчлалын Үндэсний Зөвлөлөөс олон улсын төвшинд хүрсэн гэж зөвшөөрөгдсөн зоогийн газрууд
- Бие даасан эрчим хүчний эх үүсвэр бүхий жуулчны гэр баазууд
- Цагаан идээ буюу гар урлалын бэлэг дурсгалын зүйлсээр бүрэн хангагдсан жуулчны гэр баазууд (худалдааны татварыг бууруулах)

– Гадаадын жуулчдад зориулсан бэлэг дурсгалын дэлгүүрүүдийг хамааруулж болох юм. Гадаадын хөрөнгө оруулалтын хуульд татвараас чөлөөлөх асуудлаар нэмэлт оруулах нь чухал болно.

А.7 Аялал жуулчлалын зориулалтаар газар ашиглалтад тавих хяналтын арга хэмжээнүүд

Газрыг зохистой ашиглах зорилгоор эдлэнгийн хил хязгаарыг тогтоох болон газар ашиглах зөвшөөрлийн систем, газар түрээслэх гэрээ, аялал жуулчлалын зориулалтаар газар ашиглах заавар журмыг боловсронгуй болгох шаардлагатай байна.

А.8 Лицензийн журам

Өндөр мэргэжлийн багш нар (морь унах, агаарын бөмбөрцгөөр аялах гэх мэт аялал жуулчлалын үйлчилгээний) түүнчлэн орчуулагч, аялалын хөтөч, удирдагч нарыг бэлтгэх лицензийн журмыг, жишээлбэл Японы туршлагыг харгалзан нэвтрүүлж болох юм.

А.9 Аюулгүй байдлыг хангах жишиг

Аюулгүй байдлыг хангах жишиг болон авран хамгаалах үйл ажиллагааг удирдах системийг бий болгох, лицензийн журам болон хамгаалалтын арга хэрэгслэлийг нэвтрүүлэх асуудлыг санал болгож байна. Монгол улсын Галын аюулаас хамгаалах газар нь галтай тэмцэх, галын аюулгүй байдлыг хангах Японы туршлагын зарим хэсгийг авч хэрэгжүүлж байгаа боловч түүнийг зөвхөн хэсэгчилсэн байдлаар нэвтрүүлж буй учир бүрэн хэмжээгээр үр нөлөөгөө өгч чадахгүй байна. Галын аюулаас дүрвэн зайлах мэдээллээр хангах, гал гарсан үед авран хамгаалах албыг томилох, барилга байгууламжид галын аюулгүй байдлыг хэрхэн хангасан байх талаар тодорхой зэрэглэл тогтоон ажиллах зэрэг асуудлыг шуурхай шийдвэрлэх хэрэгтэй байна.

Хөгжлийн хөтөлбөрүүд

А.10 Монголын соёлын өвийг хамгаалах хөтөлбөр

Байгалийн болон хүний нөлөөллийн улмаас Монголын соёлын өв уламжлалын зүйлс үрэгдэж эвдрэх явдал багагүй байна. Үүнд:

- Хөшөө дурсгалууд цагийн эрхээр нар салхи гэх мэт байгалийн нөлөөлөлд автан эвдэрч муудсан байна.
- Судалгаа, эрэл хайгуулын хүмүүс ухсан газраа буцааж сэргээлгүй орхисон байна.
- Орон нутгийн хүмүүс хөшөө дурсгалын газруудаас чулуу хэлтэлж авах зэргээр нэмэгдэл сүйтгэл учруулж байна.

Иймээс юуны өмнө галын аюулаас хамгаалах дохиоллын шугам тавих, орон нутгийн хүмүүст өв соёлоо хамгаалах талаар зааж сургах, мэдээллийн самбар, таних тэмдэг байрлуулах, их хэмжээгээр эвдэрч гэмтсэн хөшөө дурсгалыг зайлуулах гэх мэт арга хэмжээнүүдийг авахыг зөвлөж байна.

Шанхийн хийд, Заяа бандидийн цогчин дуганыг шуурхай сэргээн засварлах шаардлагатай байна.

А.11 Эртний түүх дурсгалт газруудыг олон нийтэд танилцуулж сурталчлах

Хар балгас, Түрэгийн хөшөөний талаар цэгцтэй тайлбар, танилцуулга хийж тавих хэрэгтэй байна. 1957 оноос эхэлсэн "Монгол дахь Түрэгийн зарим хөшөө дурсгалыг шинэчлэн сэргээн засварлаж, хадгалан хамгаалах" программыг 1997– 2001 оны хооронд хэрэгжүүлж дуусахаар тохирсон болно. Хар балгасын орчимд авто машины зогсоол, орчин тойрныг ажиглах тавцан, явган хүний замууд, мэдээллийн самбар зэргийг байгуулахыг санал болгож байна.

А.12 Олон улсын агаарын тээврийн үйлчилгээг сайжруулах

Олон улсын агаарын харилцааны хүрээнд өргөнөөр хамтран ажиллах, олон улсын агаарын тээврийн үйлчилгээг сайжруулах замаар олон улсын түвшинд өрсөлдөх чадвараа дээшлүүлэх нь чухал .

А.13 Орон нутгийн агаарын тээврийн үйлчилгээг сайжруулах

Олон улсын иргэний агаарын тээврийн байгууллагын жишиг, түүнд заасан нислэгийн аюулгүй байдлыг хангах үндсэн зарчмуудад тулгуурлан 2005 он гэхэд орон нутгийн нислэгүүдийг бүхэлд нь хувьчлах чиглэлтэй байгаа юм. Орон нутгийн агаарын тээвэрт шинэ, найдвартай онгоцоор үйлчилж, засвар үйлчилгээний төвшинг сайжруулан шинэ материалуудыг ашиглах бололцоог олгосноор үйлчилгээний чанарыг дээшлүүлэх хэрэгтэй байна.

А.14 Төмөр замын үйлчилгээг чанаржуулах

Говь (Улаан– Уул) чиглэлийн жуулчлалын программ нь цаашид хөгжих ирээдүй сайтай юм. Иймээс Улаан– Уул өртөөний орчим жуулчны бааз байгуулах, түүнчлэн галт тэргээр аялах цагийг богиносгох, хүргэж өгөх, тосож авах үйлчилгээг сайжруулах, вагон–зоогийн газар ажиллуулах зэрэг арга хэмжээнүүдийг санал болгож байна.

А.15 Нүүдэлчдийг хамруулах систем

Орон нутгийн хүмүүс, ялангуяа нүүдэлчдийн ахуй амьдралыг сайжруулахад тодорхой хэмжээний хувь нэмэр оруулах асуудал бол аялал жуулчлалыг хөгжүүлэх бодлогын нэг чухал хэсэг байх ёстой. Ийм учраас аялал жуулчлалаас олсон орлогын тодорхой хувийг нүүдэлчдийн хэрэгцээнд зориулах системийг бий болгох шаардлагатай байна.

– Нутгийн айлуудаас жуулчны гэр баазуудад нийлүүлж буй сүү, цагаан идээний эрүүл ахуйн шаардлагыг хангах асуудалд анхаарах хэрэгтэй байна. Иймээс жуулчны гэр баазуудад сүүг халааж ариутгах (пастеризац хийх) төхөөрөмжийг суурилуулахыг зөвлөж байна. Хуучин цагийн үед байсан сүү бэлтгэх систем задран унасан учир хувийн салбарыг түшиглэн бэлтгэлийн шинэ системийг нэвтрүүлж хөгжүүлэх шаардлагатай байна.

– Бэлэг дурсгалын зүйлс хийлгэхэд нүүдэлчин, малчдыг оролцуулах: Жуулчдад зориулсан бэлэг дурсгалын зүйлсийг үйлдвэрлэхэд нутгийн хүмүүс, нүүдэлчин, малчдыг татан оролцуулах ажлыг чанаржуулан, түүний маркетингийг зохион байгуулах менежментийн системийг хэрэгжүүлэх шаардлагатай байна. Энэхүү систем нь нутгийн хүмүүс, нүүдэлчид болон гэр баазын эзэд зэрэг хүмүүсийн хоорондын хамтын хүчин дээр хэрэгжих ёстой. Үүний дотор, шаардлагатай түүхий эд материалыг нутгийн хүмүүс, нүүдэлчдэд хүргэж өгөх, хийсэн бэлэг дурсгалын зүйлсийг Улаанбаатар руу татах, гэр бааз болон бусад газруудад эдгээр бэлэг дурсгалын зүйлсийг худалдаж байгаа хүмүүст нийлүүлэх зэрэг ажлыг гэр баазын эздүүд зохион байгуулах ёстой. Санал болгосон Гар урлалын зүйлсийн төв нь бэлэг дурсгалын зүйлсийн загвар бүтээх, чанарыг сайжруулах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх үүргийг гүйцэтгэх бөгөөд түүнийг түшиглүүлэн мэргэжлийн сургалтыг явуулах, техник тоног төхөөрөмжийг боловсронгуй болгох ажлыг зохион байгуулж болох юм.

– Нүүдэлчдийн соёлыг жуулчдад танилцуулсан үзвэрүүд: Жуулчдад иймэрхүү шинэ төрлийн үзвэрүүдээр үйлчлэх ажлыг зохион байгуулах үүднээс юуны өмнө нарийвчилсан судалгаануудыг хийж гүйцэтгэсэн байх шаардлагатай. Жишээлбэл, Монголын уламжлалт ахуй амьдрал, ёс заншлыг харуулсан эсгий хийх гэх мэт өдөр тутмын үйл ажиллагаанд хамтран оролцох нь олны сонирхол татсан, их ирээдүйтэй программ болж болох юм.

А.16 Археологийн болон зэрлэг ан амьтан, ургамлын үндэсний зурагт каталог, газрын зураг

Онгон байгалийг хамгаалах, Монгол дахь эко – жуулчлалыг хөгжүүлэхэд үнэ цэнтэй мэдээллийн хэрэгсэл болох Монголын амьд байгалийн зурагт каталогийг бүтээж гаргах явдал онцгой ач холбогдолтой. Энэхүү каталогийн тодорхой хэсэг бүлэг бүрээр (ан амьтан, шувууд, хоёр нутагтан, хэвлээр явагч, шавьж хорхой, загас болон ургамлын аймаг) редактор зохиогчдыг олж томилох, хэвлэлд бэлтгэхтэй холбогдсон тоо баримтуудыг цуглуулах зэрэг ажлуудыг хийх хэрэгтэй байна.

А.17 Эко–жуулчлалын мэдээллийн материалыг бүрдүүлэх

Эко– жуулчлалын ерөнхий гарын авлага (журам зааврууд) бэлтгэх, энэ чиглэлийн аялал жуулчлалын аюулгүй байдлыг хангах жишиг гаргах, Монголын экологийн системийн талаар товч танилцуулга боловсруулах, зохион байгуулж болох эко–аялалуудын (аялалын төрөл, хугацаа, шаардагдах зардал, хамгийн зохимжтой улирал, нэмэлт арга хэмжээнүүд) тухай дэлгэрэнгүй мэдээлэл, эко– жуулчлалын чиглэлээр ажилладаг улсын бүртгэлтэй жуулчны компануудийн жагсаалт гэх мэтчилэн материалуудыг бэлтгэж гаргах нь зохистой.

А.18 Хүрээлэн буй орчны менежментийн нэгдсэн судалгаа

Хүрээлэн буй орчныг хамгаалах нэгдсэн менежментийн программыг бий болгох үүднээс байгаль орчин болон нийгэм соёлын талаархи, ялангуяа

амьд байгалийн чиглэлээр нарийвчилсан судалгаа хийх ажлыг нэн шуурхай зохион байгуулах шаардлагатай байна. Үүнд:

- (1) Амьд байгалийн талаар судалгаа хийж, түүнийг Үндэсний амьд байгалийн менежментийн программ боловсруулах явцад ашиглах
- (2) Үндэсний нүүдэлчдийн газар нутгийн менежментийн программыг хэрэгжүүлэх үүднээс нийгэм соёлын орчны судалгаа явуулах
- (3) Ан агнуурын бүсчлэлийг шинээр тогтоох судалгаа хийх

А.19 Хилийн чанад дахь маркетинг

2005 он хүртэлх хугацаанд дор дурдсан арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэхийг санал болгож байна. Үүнд:

- Аялал жуулчлалын чиглэлээр зохиогддог олон улсын зарим томоохон үзэсгэлэн яармагт оролцох
- Гадаадын хэвлэл мэдээлэл, жуулчдын байгууллагуудтай холбоо харилцаа тогтоох
- Гадаадын хэвлэл мэдээлэл жуулчдын байгууллагуудад зориулж өөрсдийгөө танилцуулах тусгай аялал зохион байгуулах
- 2005 оныг " Монголд зочлох жил" болгон зарлах
- Токио болон Франкфурт хотод жуулчны төлөөлөгчийн газруудыг гэрээгээр нээн ажиллуулах
- Хилийн чанад дахь сурталчилгаанд зориулан төрөл бүрийн мэдээллийн материал, түүнчлэн жуулчлалын гол гол төвүүд болон орон нутгийн байгууллагуудын талаархи мэдээлэл сурталчилгааны материалуудыг боловсруулж гаргах
- Жуулчлалын бага ачааллын улирлын үеэр (8– 4 дүгээр сар) төрөл бүрийн олон нийтийн арга хэмжээ, фестивалиудыг зохион байгуулах

А. 20 Улаанбаатар хотын зочид буудлуудыг хөгжүүлэх ерөнхий чиглэл

Жуулчдын ирээдүйн эрэлт хэрэгцээг хангах үүднээс одоо байгаа зочид буудлуудын нийт орны тоог 40– 100 хувиар нэмэгдүүлэх (одоогийн байдлаар гадаадын жуулчдад зориулсан 2600 орчим ор байгаа болно) шаардлага гарч байгаа юм.

А. 21 Бүс нутгуудаар гэр бааз хөгжүүлэх ерөнхий чиглэл

Улаанбаатарын орчимд: Улаанбаатар орчим дахь гадаадын жуулчдад зориулсан гэр баазуудын орны багтаамж нь Судалгааны багийн тооцоолсноор 2005 он хүртэл хангалттай болно.

Хархорины бүс нутагт: Жуулчны ид ачааллын 7,8 дугаар сард гэр баазуудын орны бололцоо хүрэлцэхгүй тооцоо гарч байна. Үүнд, 2005 он гэхэд 7 дугаар сард 2000 жуулчин – ор (өдөрт 70 ор), 8 дугаар сард 5000 жуулчин– ор (өдөрт 170 ор буюу жуулчны 1 гэр бааз) дутагдаж байна.

Өмнөговийн бүс нутагт: Жуулчны ид ачааллын 7,8 дугаар сард гэр баазуудын орны бололцоо мөн адил хүрэлцэхгүй тооцоо гарч байна. Үүнд,

2005 он гэхэд 7 дугаар сард 9000 жуулчин – ор (өдөрт 300 ор), 8 дугаар сард 13000 жуулчин– ор (өдөрт 400 ор буюу жуулчны 2 гэр бааз) дутагдаж байгаа юм.

Аялал жуулчлалын газар нь зочид буудлуудыг хөгжүүлэх, тэдгээрийн удирдлага, менежментийг зохион байгуулах, тухайлбал ор хоногийн зохистой тооны талаар ерөнхий чиглэл гаргах, зочид буудлуудын аюулгүй байдлыг хангах, зэрэглэл тогтоох зэрэг асуудлуудаар тодорхой зааварчлага өгөх хэрэгтэй байна..

A.22 Улаанбаатар хотын автобусны үйлчилгээний тухай гарын авлага– танилцуулга

Улаанбаатар хотын захиргаанаас жуулчдад зориулан автобусны үйлчилгээний чиглэл маршрутыг харуулсан схем, зогсоолууд дээр дэлгэрэнгүй танилцуулга бүхий мэдээллийг бэлтгэсэн байх.

A.23 Автобус болон үзвэрийн газруудад хэрэглэхэд тохиромжтой нэгдсэн тасалбар нэвтрүүлэх

2005 он гэхэд Улаанбаатарын автобусаар үйлчлүүлэх болон бүх музей үзвэрийн газруудад нэвтрэх нэг өдрийн хүчинтэй тасалбарын тохиромжтой системийг бий болгон нэвтрүүлэх.

2) Улсын өмчийн хүрээний төслүүд

Соёлын аялал жуулчлалыг өргөжүүлэх

Б. 1 Улаанбаатар дахь Богд хааны музейг сайжруулах

- Өвлийн ордныг засварлан сэргээх (ордны суурь, хана, гадна талын чимэглэл болон бүх барилга байгууламжуудыг сэргээн засварлах)
- Ордныг хүрээлсэн гадна хашааг (500 м урт) нийтэд нь сэргээн засварлах
- Сүм дуганыг тойрсон шавар ханыг (250 м урт) сэргээн засварлах
- Захиргааны шинэ байр, агуулахыг барьж байгуулах, шинэ үйлчилгээнүүдийг нэвтрүүлэх
- Музейн гадна дотно талын зам талбайнуудын өнгөлгөөг сайжруулах
- Сүм дугануудыг сэргээн засварлах (дээвэр, шал, будгийг)
- Билетийн касс, мэдээллийн самбаруудыг байгуулах

Б.2 Монголын соёлын хүрээлэн

- Улаанбаатар хотоос баруун тийш 35 км– т байгаа одоогоор цөөн малчин амьдарч буй мал бэлчээрийг Соёлын хүрээлэн байгуулахаар сонгож авсан.
- Хүрээлэнгийн гол бэлэг дэмбэрэл болсон том цагаан гэр төвд нь байрлах бөгөөд тэр нь Монголын 7 ястан үндэстнийг төлөөлсөн ястан үндэстнүүдийн түүх, нутгийн цаг агаар, аж амьдралын хэвшлийг харуулсан 7 гэрээр хүрээлүүлсэн байх болно. Мөн Монгол үндэсний хувцас, Монголын ардын хөгжмийн зэмсэг, Монголын ястан үндэстэн, Монголын адуу морьд гэсэн

сэдэвчилсэн үзмэрүүд тавигдсан дунд зэргийн гэрүүд захаар нь байрласан байх юм.

– Хүрээлэнгийн гадна талд (1.5– 3.0 км –ийн цаана) малчдын гэр байх бөгөөд тэнд уг хүрээлэнд зочилж байгаа хүмүүс хүрэлцэн очиж нүүдэлчдийн ахуй амьдралыг сонирхох, түүнд оролцож болох бололцоотой байх ёстой.

Б.3 Эрдэнэзуугийн ойр орчмыг тохижуулах

Ойр орчимд нь явган хүний замууд тавих, чулуун хөшөө дурсгал болон тайлбар бичиг, амрах сандлууд байрлуулах, зүлэг, цэцгийн мандал байгуулах зэрэг арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхээс гадна захиргааны барилга байгууламж, сүм хийдийг шинэчлэхийг санал болгож байна.

Б.4 Хархорины Зочдыг хүлээн авах төв

Тус төвийг Эрдэнэзуугийн аман дээр (ойролцоогоор 3000 ам. м талбайтай) байгуулж зочид жуулчдад Монгол Улсын өнгөрсөн түүх, Хархорины талаар (чулуун зэвсэгийн үе, Түрэг, Уйгар, Эрдэнэзуу г. м.) өргөн мэдээлэл өгөхөд зориулах болно.

Улаанбаатар хотыг жуулчлалын гол төв болгон хөгжүүлэх

Б.5 Улаанбаатарт аялал жуулчлалын байнгын зам маршрут тогтоож хөгжүүлэх

ТАСИС группээс боловсруулсан зам маршрутын загвар жишигт түшиглэн жуулчдын аялалын замуудыг байгуулж хөгжүүлэх асуудал чухал. Үүнд, Сүхбаатарын талбай дээр тэмдэгжүүлэх системийг бүрэн нэвтрүүлсэн (замын маршрут чиглэлийг заасан самбарууд, бусад мэдээллийн самбарууд, газарчлах тэмдэгүүд) Жуулчдын мэдээллийн төв байгуулах, замуудын өнгөлгөө засалтыг сайжруулах зэрэг арга хэмжээнүүдийг хамааруулж байна.

Б.6 Улаанбаатарт жуулчдын гудамж талбай байгуулах

Хот суурин газрын аялал жуулчлалын үйлчилгээний үндсэн түшиц газар болох үүргийг хүчтэй болгох, түүнчлэн Монголын олон улсын аялал жуулчлалын гол төв болох ролийг нь бэхжүүлэх зорилгоор жуулчдын сонирхолыг татахуйц гоё сайхан хорооллыг барьж байгуулах шаардлагатай. "Худалдааны гудамж 2005" төслийн хүрээнд бэлэг дурсгалын зүйлс, гар урлалын шинэ төв, зоогийн газрууд, гадаа зассан тайз зэргийг багтаасан Жуулчдын гудамж талбай, үйлчилгээний төвүүд байгуулах асуудлыг шийдвэрлэхийг санал болгосон.

Б.7 Улаанбаатарт бэлэг дурсгалын зүйлс болон гар урлалын бүтээгдэхүүний төв байгуулах

Жуулчдын гудамж талбайд үйлвэрлэлийн явцыг харуулсан дэлгүүр, гар урлалын мухлаг хоршоо, үлгэр загварын дэлгүүрүүд байхаас гадна Улаанбаатарт бэлэг дурсгалын болон гар урлалын зүйлсийн төв (ойролцоогоор 960 ам.м талбайтай) нээн ажиллуулахаар тусгасан.

Байгалийн аялал жуулчлалыг хөгжүүлэх

Б.8 Тэрэлжийн Зочдыг хүлээн авах төв

Горхи– Тэрэлжийн үндэсний дархан цаазат газрын аман дээр засвар үйлчилгээний хувьд хялбарыг нь бодолцож модон байшингийн зохиомжоор баривал зохистой. Байшинг тойрсон модон тавцан дээрээс зочид эргэн тойрны байгалийн сайхныг ажиглах боломжтой байх бөгөөд тус төвийн нийт шалны талбайг 130 ам. м орчим байхаар тооцоолж байна.

Б.9 Говь дахь Зочдыг хүлээн авах төв

Ёлын Амны эхэнд байрлах бөгөөд энэ нутгийн байгалийн талаар зочдод тодорхой танилцуулах, тухайлбал тэнд нутагшсан ургамал, ан амьтдын физиологийн болон биологийн онцлог, бүс нутгийн хөгжлийн ерөнхий чиглэл, хамгаалагдсан газарт мөрдөгдөж буй заавар журмыг танилцуулах үүрэгтэй байхын хамт захиргааны ажлыг эрхэлнэ. Германы техникийн хамтын ажиллагааны сантай санал солилцсоны дагуу байгаль орчныг хамгаалах асуудлыг бодолцон хөндийд зөвхөн морьд, үхэр тэргийг тээврийн хэрэгсэл болгон ашиглахаар тооцсон.

Б.10 Шувууд ажиглах газрыг бэлдэж байгуулах

Зэрлэг шувууд, ялангуяа нүүдлийн шувуудыг ая тухтай ажиглах, байгалийн сайхныг харж шимтэх газруудыг Улаанбаатар хотын орчимд болон Хархоринд (Өгийн нуур) шинээр байгуулахыг зөвлөж байна. Эко– жуулчид (ялангуяа Европ, Америкийн) Монгол оронд олон төрлийн нүүдлийн шувууд элбэг байдаг гэдгийг сайн мэддэг билээ. Эдгээр шувуудыг ажиглах газрууд нь жуулчдын шинэ нэгэн үзвэр болох төдийгүй гол төлөв зун цугладаг шувуудыг байнга нүүдэллэн ирж байх нөхцөл боломжийг олгоно.

Бусад хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээнүүд

Б.11 Хархорин чиглэлийн жуулчдын зам

Хархорин– Хар балгас чиглэлийн 30 км урттай хэсэг зам, мөн Хархорин–Хөшөө цайдам чиглэлийн 47 км урттай хэсгийг сайжруулсан хайрган замын болгон засаж тохижуулахыг санал болгож байна. Одоогийн Хархорин болон Хархорины орчим дахь жуулчдын гол газруудад явж очих зам нь үндсэндээ автомашины дугуйнд дагтаршсан шороон харгүй замууд байгаа учраас түүгээр аялахад маш их цаг зарж тав тух алдахад хүрч байгаа юм.

Б.12 Улаанбаатар– Хархорин төв автозамыг тэмдэгжүүлэх

Улаанбаатар– Хархорины төв автозамын дагуу одоогоор ямар нэгэн замын тэмдэг, дохиоллын систем алга байна. Тиймээс жуулчдын замын чиглэлийг заасан тэмдэг, хурд хязгаарлах анхааруулга, ан амьтдаас болгоомжлох тэмдэг зэргийг хийж тавих нь илүү ая тухтай, аюулгүй зорчих боломжийг бүрдүүлнэ.

Б.13 Халуун рашаан, сувиллын газруудыг сайжруулах

Орон нутгийн хүмүүсийн өсөн нэмэгдэж буй эрэлт хэрэгцээг хангах үүднээс Улаанбаатар, Хужирт, Шаргалжуутын рашаан сувиллын газруудыг шинэчлэн засварлах хэрэгтэй байна.

Б.14 Аялал жуулчлалын хувийн секторт зээл олгох тогтолцоо

Хувийн пүүс, компаниудын зүгээс жижиг дунд үйлдвэрийн хэлбэрээр аялал жуулчлалын материаллаг баазыг байгуулах (гэр бааз, замын дагуух амралтын газрууд г. м.) арга хэмжээг санхүүжүүлэхэд гадаад орнуудаас хөнгөлөлттэй нөхцөлөөр олгодог 2 үе шаттай зээлийн системийг ашиглах боломжтой.

3) Хувийн хэвшлийн төслүүд

В.1 Улаанбаатар– Хархорин төв автозамын дагуу алжаал тайлах амралтын газрууд байгуулах

Одоогийн байдлаар Улаанбаатар– Хархорин чиглэлийн автозамын дагуу амралт зогсоолын газрууд тун цөөхөн байгаа бөгөөд тэдгээр нь маш хүнд байдалтай байна. Тийм учраас амралтын барилга байгууламжууд (зоогийн газар, дэлгүүр мухлаг, биеэ засах газар, шатахуун түгээврийн газрууд г. м.) барих нь илүү ая тухтай аюулгүй зорчих боломжийг олгоно.

В. 2 Гэр баазуудын нөхцөл, материаллаг баазыг сайжруулах

Илүү тохитой гэр баазуудыг байгуулах. Үүнд, эрчим хүчний хангамж, харилцаа холбоо, хатуу хог устгах, бие засах газрууд байгуулах гэх мэт асуудлуудыг шийдвэрлэх.

В. 3 Өмнөговийн онгоцны буудлын зурвасыг сайжруулах

Өмнөговийн жуулчны баазын онгоцны тусгай буудлыг бүхэлд нь (онгоц буух зурвас, навигацын систем, цаг уурын ажиглалтын систем) сайжруулах явдал Өмнөговь хүртэл аюулгүй ая тухтай аялах боломжийг бүрдүүлнэ.


В. 4 Спортын идэвхтэй амралтыг өргөжүүлэх

Жуулчдын сонирхолыг татах боломжийг нэмэгдүүлэх үүднээс төрөл бүрийн спортын үйл ажиллагааг (морь унах, автомашинаар аялах, агаарын бөмбөрцгөөр нисэх, шүхрээр буух, агаарын чөлөөт уналт, дельтопланаар нисэх, завь салаар аялах, загас барих) хөгжүүлэх хэрэгтэй. Энд гол анхаарах зүйл бол аюулгүй байдлыг хангах, байгаль орчинг хамгаалах асуудал юм.

В. 5 Морьдын хүрээлэн

Морьдын музей, морь унаж сурах сургууль, морин тойруулгаас бүрдсэн Морьдын хүрээлэн байгуулахыг санал болгож байна.


Богд хааны музей



- | | | |
|-----------------------------------|---|--|
| 1 Лазрин сүм | — | Үйлчилгээний шинэ төв, явган хүний зам |
| 2 Олон бурхдын сүм | — | Явган хүний хуучин зам |
| 3 Богдын номын сан сүм | — | |
| 4 Найдан сүм | — | |
| 5 Уран зургийн сүм | — | |
| 6 Торгон зээгт наамал бурхдын сүм | — | |
| 7 Аравсай | — | |
| 8 Аравсай | — | |
| 9 Махранзын сүм | — | |
| 10 Амгалан энхийн хаалга | — | |
| | └ | Хэрэм |

МОНГОЛ УЛСЫН ДЭД БУТЦИЙН ХӨГЖҮҮЛИЙН ЯАМ
 ЯПОНЫ ОЛОН УЛСЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ АГЕНТЛАГ (ЖАЯКС)
 МОНГОЛ УЛСАД ҮНДЭСНИЙ АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫГ
 ХӨГЖҮҮЛЭХ МАСТЕР ТӨЛӨВЛӨГӨӨ
Хүснэгт 5.1
Богд хааны музейг засч сайжруулах төлөвлөгөө
 ПАДЕКО Ко., Лтд/Ниппон Коэй Ко., Лтд.

Богд хааны музей



- | | | |
|-----------------------------------|---|--|
| 1 Лаврин сүм | — | Үйлчилгээний шинэ төв, явган хүний зам |
| 2 Олон бурхдын сүм | — | Явган хүний хуучин зам |
| 3 Богдын номын сан сүм | — | Хэрэм |
| 4 Найдан сүм | — | |
| 5 Уран зургийн сүм | — | |
| 6 Торгон зээгт наамал бурхдын сүм | — | |
| 7 Аравсай | — | |
| 8 Аравсай | — | |
| 9 Махранзын сүм | — | |
| 10 Амгалан энхийн хаалга | — | |

МОНГОЛ УГСАД ДЭД БҮТЦЛЭН ХӨГЖҮҮЛЭХ ЯАМ
 ОРОНЫ ОЛОН УГСЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ АГЕНТЛАГ ФАЙЖА

МОНГОЛ УГСАД ҮНДЭСНИЙ АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫГ
 ХӨГЖҮҮЛЭХ МАСТЕР ТӨЛӨВЛӨГӨӨ


Хүснэгт 5.1

Богд хааны музейг засч
 сайжруулах төлөвлөгөө

ПАДЕКО Ко., Лтд/Ниппон Коэй Ко., Лтд.

Богд хааны музей


○ Мэдээллийн самбар ○



○ Ёслолын өргөө ○



Зураг А



МОНГОЛ УЛСЫН ДЭД БҮТЦИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ

ЯПОНЫ ОЛОН УЛСЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ АГЕНТЛАГ ФАЙЖА

МОНГОЛ УЛСАД ҮНДЭСНИЙ АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫГ
ХӨГЖҮҮЛЭХ МАСТЕР ТӨЛӨВЛӨГӨӨ


Хүснэгт 5.2

Мэдээллийн самбарын төлөвлөгөө
болон тасалбар түгээх цэгийг
шинэчлэх төлөвлөгөө


ПАДЕКО Ко., Лтд/Ниллон Коэй Ко., Лтд.

Богд хааны музей


○ Мэдээллийн самбар ○



○ Ёслолын өргөө ○



Зураг А




Зураг А

МОНГОЛ УЛСЫН ДЭД БҮТЦИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ
ЯПОНЫ ОЛОН УЛСЫН ХАМТЫН АЖИЛГААНЫ АГЕНТЛАГ (ОАЯИКА)
МОНГОЛ УЛСАД ҮНДЭСНИЙ АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫГ
ХӨГЖҮҮЛЭХ МАСТЕР ТӨЛӨВЛӨГӨӨ


Хүснэгт 5.2

Мэдээллийн самбарын төлөвлөгөө болон тасалбар түгээх цэгийг шинэчлэх төлөвлөгөө


ПАДЕКО Ко., Лтд/Ниппон Коэй Ко., Лтд



Эрдэнэзуугийн музей



Зураг А




МОНГОЛ УЛСЫН ӨЗД БҮТЭЙЛЭН ХӨГЖИЙЛЭХ ЯАМ
 ЯПОНЫ ОЛОН УЛСЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ АГЕНТЛАГ САНХАА
 МОНГОЛ УЛСАД ҮНДЭСНИЙ АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫГ
 ХӨГЖҮҮЛЭХ МАСТЕР ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 5.4
 Эрдэнэзуугийн музейг засч
 сайжруулах төлөвлөгөө


ПАДЕКО Ко., ЛгдНиппон Коэй Ко., Лгд.



Хүснэгт 5.5
Эрдэнэзуугийн музей болон
Хархорины Зочдыг хүлээн авах төв



Гар урлалын бүтээгдэхүүний төв бүхий жуулчдын үйлчилгээний төв




0 10 20 30 40 50m

МОНГОЛ УЛСЫН ДЭД БУТЦИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ
ЭЛСЭН ОЛОН УЛСЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ АГЕНТЛАГ (ЖААХА)
МОНГОЛ УЛСАД ҮНДЭСНИЙ АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫГ
ХӨГЖҮҮЛЭХ МАСТЕР ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 5.7
Улаанбаатар хотод жуулчдад зориулсан үйлчилгээний төв байгуулах төлөвлөгөө

ПАДЕКО Ко., Лтд/Нилпон Козэй Ко., Лтд.

Өмнөговийн Зочдыг хүлээн авах төв



МОНГОЛ УЛСЫН ДЭД БҮТЭЙН ХӨГЖҮҮЛЭХ ЯАМ ЯГОНЫ БОЛОН УЛСЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ АГЕНТЛАГ ШАХЖА
МОНГОЛ УЛСАД ҮНДЭСНИЙ АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ МАСТЕР ТӨЛӨВЛӨГӨӨ
Хүснэгт 5.8 Өмнөговийн Зочдыг хүлээн авах төвийг хөгжүүлэх
ПАДЕКО Ко., Лтд/Нилпон Коэй Ко., Лтд.

6. ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛИЙН ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨРҮҮДИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨ

6.1 Хэрэгжүүлэх хуваарь

Тэргүүлэх чиглэлийн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх хуваарийг дор үзүүлэв.

	1998	1999	2000	2001	2002	2003	2004	2005
А ХӨТӨЛБӨРҮҮД								
1 Засаг захиргааны байгууллагуудыг бэхжүүлэх								
А- 1 Аялал жуулчлалын үндэсний зөвлөлийг тогтмол	Δ							
А- 2 Аялал жуулчлалын газар, Аялал жуулчлалын үндэсний зөвлөлийн хоорондын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах замаар аялал жуулчлалын	Δ							
А- 3 Аймгуудын засаг захиргааны байгууллагуудыг бэхжүүлэх								
2 Хүний нөөцийг хөгжүүлэх								
А- 4 Аялал жуулчлалын сургалтыг сайжруулах								
А- 5 Байгаль хамгаалагчдын сургалт явуулах								
3 Эрх зүйн зохицуулалтыг сайжруулах								
А- 6 Аялал жуулчлалын салбар дахь хөрөнгө оруулалтыг хөхүүлэн дэмжих	Δ							
А- 7 Газар ашиглалтад тавих хяналтын арга хэмжээнүүд								
А- 8 Лицензийн журам								
А- 9 Аюулгүй байдлыг хангах жишиг								
4 Хөгжлийн хөтөлбөрүүд								
А- 10 Монголын соёлын өвийг хамгаалах хөтөлбөр								
А- 11 Эртний түүх дурсгалт газруудыг олон нийтэд танилцуулж Сурталчлах								
А- 12 Олон улсын агаарын тээврийн үйлчилгээг сайжруулах								
А- 13 Орон нутгийн агаарын тээврийн үйлчилгээг сайжруулах								
А- 14 Төмөр замын үйлчилгээг чанаржуулах								
А- 15 Нүүдэлчдийг хамруулах тогтолцоо								
А- 16 Археологийн болон ээрлэг ан амьтан, ургамлын								
А- 17 Эко- жуулчлалын мэдээллийн материалыг бүрдүүлэх								
А- 18 Хүрээлэн буй орчны менежментийн нэгдсэн судалгаа								
А- 19 Хилийн чанад дахь маркетинг								
А- 20 Улаанбаатар хотын зочид буудлуудыг хөгжүүлэх ерөнхий чиглэл	Δ							
А- 21 Бүс нутгуудаар гэр бааз хөгжүүлэх ерөнхий чиглэл	Δ							
А- 22 Улаанбаатар хотын автобусны үйлчилгээний тухай гарын авлага- танилцуулга								
А- 23 Автобус болон үзвэрийн газруудад хэрэглэхэд								

Томьёолол

———— Зохион байгуулалтын арга хэмжээ болон санхүүжүүлэлтийн бэлтгэл ажил
 Δ Гүйцэтгэл

----- Хөтөлбөрүүдийн хэрэгжүүлэлт

Эх сурвалж: ЖАЙКА- гийн Судалгааны баг

хийх) болон зохион байгуулалтын арга хэмжээг (байгаль орчны урьдчилсан үнэлгээ) 1999– 2000 онуудад, зураг төсөл барилгын ажлыг 2001– 2003 онуудад дор дурдсан хүснэгтэд заасны дагуу хэрэгжүүлж гүйцэтгэхээр төлөвлөв .

Тэргүүлэх чиглэлийн төслүүдийг хэрэгжүүлэх хуваарь

	1998	1999	2000	2001	2002	2003	2004	2005
Б УЛСЫН ӨМЧИЙН ХҮРЭЭНИЙ ТӨСЛҮҮД								
1 Соёлын аялал жуулчлалыг өргөжүүлэх								
Б- 1 Богд хааны музейг засч сайжруулах								
Б- 2 Монголын соёлын хүрээлэн								
Б- 3 Эрдэнэзуугийн ойр орчмыг тохижуулах								
Б- 4 Хэрхорины Зочдыг хүлээн авах төв								
2 Улаанбаатар хотыг жуулчлалын гол төв болгон хөгжүүлэх								
Б- 5 Улаанбаатарт аялал жуулчлалын байнгын зам маршрут тогтоож хөгжүүлэх								
Б- 6 Улаанбаатарт жуулчдад зориулсан гудамж талбай байгуулах								
Б- 7 Улаанбаатарт бэлэг дурсгалын зүйлс болон гар урпалын бүтээгдэхүүний төв Байгуулах								
3 Байгалийн аялал жуулчлалыг хөгжүүлэх								
Б- 8 Тэрэлжийн Зочдыг хүлээн авах төв								
Б- 9 Говь дахь Зочдыг хүлээн авах төв								
Б- 10 Шувууд өмжлэх газрыг бэлдэж байгуулах								
4 Бусад хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээнүүд								
Б- 11 Хархорин чиглэлийн жуулчдын зам								
Б- 12 Улаанбаатар– Хархорины төв автозамыг тэмдэгжүүлэх								
Б- 13 Халуун рашаан, сувиллын газруудыг засч сайжруулах								
Б- 14 Аялал жуулчлалын хувийн секторт зээл олгох тогтолцоо								
В ХУВИЙН ХЭВШЛИЙН ТӨСЛҮҮД								
В- 1 Улаанбаатар– Хархорин төв автозамын дагуу алжаал тайлах амралтын газрууд байгуулах								
В- 2 Гэр баазуудын нөхцөл, материаллаг баазыг сайжруулах								
В- 3 Өмнөговийн онгоцны буудлын зурвасыг сайжруулах								
В- 4 Спортын идэвхтэй амралтыг өргөжүүлэх								
В- 5 Морьдын хүрээлэн								

Томъёолон

— Зохион байгуулалтын арга хэмжээ болон санхүүжүүлэлтийн бэлтгэл ажил

□ Барилга байгууламжуудын зураг төслийг боловсруулах, барилгыг барих

▨ Барилгыг барих/Хөгжүүлэх

→ Хэрэгжүүлэх нь

Эх сурвалж: ЖАЙКА-гийн Судалгааны баг

6.2 Хэрэгжүүлэх байгууллага

Дэд бүтцийн хөгжлийн яамны харьяанд Аялал Жуулчлалын Үндэсний Зөвлөлийг 1998 оны 10 дугаар сард байгуулсан. Үүний зэрэгцээгээр Засгийн газрын хуралдаанаас Аялал Жуулчлалын Үндэсний Зөвлөлийн хяналтын дор үйл ажиллагаагаа явуулж байх төсөл хэрэгжүүлэгч агентлагаар Аялал Жуулчлалын Үндэсний Төвийг мөн байгуулсан билээ. Энэ төвийн хүрээнд аялал жуулчлалын төслүүдийг хэрэгжүүлэх асуудлыг бүрэн хариуцах үүрэг бүхий Төслийг хэрэгжүүлэх хэсгүүдийг холбогдох яамдаас томилсон гишүүдээс бүрдүүлэн байгуулах шаардлагатай байгаа юм. Холбогдох яам, хэрэгжүүлэх агентлагууд музейг сэргээн засварлах гэх мэт тодорхой гүйцэтгэх ажлуудыг тус бүрээр нь хариуцан авах нь зүйтэй байна.

6.3 Өртгийн тооцоо

Тэргүүлэх чиглэлийн төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх нийт өртөг нь дор нэгтгэн харуулснаар ойролцоогоор 37 сая ам. доллар (ойролцоогоор 4.3 тэрбум иен, 1 ам. доллар= 115 иен) байх тооцоотой. Үүнээс 19 сая ам. доллар нь тэргүүн чиглэлийн төслийг хэрэгжүүлэхэд шаардагдана. Аялал жуулчлалын салбар нь гадаад валют олох үр ашигтай нэг арга зам мөн учир тэргүүлэх чиглэлийн төслүүдийг санхүүжүүлэх гол эх үүсвэр болгон гадаадын хөнгөлөлттэй зээлийг ашиглахаар тооцсон байгаа. Тэргүүлэх чиглэлийн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийн тухайд гэвэл техникийн хамтын ажиллагаа болон буцалтгүй тусламжийг зориулахаар тусгасан болно.

Тэргүүлэх чиглэлийн төсөл, хөтөлбөрүүдийг өртгийн тооцоо

	Нийт өртөг	
	триллион төг.	сая ам. доллар
1. Хөтөлбөрүүд	11,5	13,2
2. Улсын өмчийн хүрээний төслүүд	16,7	19,2
3. Хувийн хэвшлийн төслүүд	4,1	4,7
Бүгд	32,3	37,1

Тайлбар: Инженерийн байгууламж биет материалын зардлыг оруулан тооцов. Үнийн өсөлтийг тусгаагүй. 1 ам. доллар= 870 төгрөг
Эх сурвалж: ЖАЙКА-гийн Судалгааны баг

7. ҮНЭЛГЭЭ

7.1 Эдийн засгийн үнэлгээ

Тэргүүлэх чиглэлийн төсөл, программуудын эдийн засгийн үнэлгээг Эдийн Засгийн Өгөөжийн Дотоод Илтгүүрийн (ЭЗӨДИ) аргачлалаар тооцож гаргасныг доор нэгтгэн үзүүлэв. ЭЗӨДИ нь 31.1 хувь байгаа нь тэргүүн чиглэлийн төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх нь зохистой болохыг нотолж байна.

Эдийн засгийн үнэлгээний нэгдсэн үзүүлэлт (ам.доллараар)

Онууд	Анхны өртөг	Засвар үйлчилгээний өртөг	Үр ашиг	Тэнцэл
1998	0	0		
1999	0	190	4167	3977
2000	6919	311	3195	- 4035
2001	6119	491	3190	- 3421
2002	14027	612	3394	- 11245
2003	11596	935	3156	- 9375
2004	2619	1393	2813	- 1199
2005	1956	1648	2411	- 1193
2006		2066	17716	15650
2007		2307	16914	14607
2008		2548	19888	17340
2009		3030	20338	17308
2010		3210	21675	18465
2011		3512	21394	17882
2012		3874	20275	16401
2013		4355	25774	21419
2014		4777	21185	16408
2015		5379	22357	16978
			ЭЗӨДИ	31.1 хувь

Агаарын тээврийн үйлчилгээг сайжруулах арга хэмжээг авч хэрэгжүүлээгүй, жуулчлалын үнийг тэргүүн чиглэлийн төсөл, хөтөлбөрүүдэд зааснаас өндөр байх нөхцөлд энэ нь аялал жуулчлалын эрэлт хэрэгцээний өсөлтөд сөргөөр нөлөөлөх тул ЭЗӨДИ 18 хувиас хэтрэхгүй байх төлөвтэй байна.

7.2 Санхүүгийн үнэлгээ (Хөнгөлөлттэй зээлийг эргүүлэн төлөх)

Монголын Засгийн газар, тэргүүлэх чиглэлийн төслүүдийн улсын өмчийн хүрээнд хэрэгжигдэх төслүүдийг хэрэгжүүлэх зорилгоор гадаад орнуудын тусламжийн байгууллагуудаас зээл авах нөхцөлд энэхүү зээлийг гадаадын жуулчид байрласан зочид буудлынхаа үнэд төлсөн төлбөрт ногдуулах татварын орлогоос бүрэн төлж барагдуулах боломжтой бөгөөд уг татварын хэмжээг тооцож гаргасан байгаа. Тооцоо ёсоор хамгийн дээд хэмжээгээр гэхэд 6.29 хувийн татвар ногдуулсан нөхцөлд бүх авсан зээлийг эргүүлэн төлөх бололцоотой.

7.3 Орчны анхдагч үнэлгээ

Улаанбаатар хотын орчин

- 1) Байгаль орчин : гольфын талбай, цанын амралтын газар байгуулах нь байгаль орчинд тодорхой хэмжээгээр нөлөөлөх учраас энэхүү нөлөөллийг нарийвчлан тогтоох үнэлгээ хийх шаардлагатай нь ойлгомжтой. Тэгээд ч зарим төслүүд нэг дор хэт олон хүн бөөгнөрч цуглах явдлыг үүсгэж болох талтай. Мөн барилгын ажлын явцад гарч болох хөрс, ус, агаарын бохирдол, хог хаягдлын сөрөг нөлөөллийг бууруулах, арилгахад чиглэгдсэн зохистой менежментийн төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлэх нь зүйтэй болно. Бүх төсөл, хөтөлбөрүүд нь Туул голын сав хөндийд хэрэгжигдэхээр төлөвлөгдсөн байгаа учраас одоогийн хүрээлэн байгаа орчин тойрон болон цаашид эдгээр төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлснээр гарч болзошгүй нэмэлт үр дагавар голын эко– системд хэрхэн нөлөөлөхийг судалж дүгнэх хэрэгтэй байна.
- 2) Нийгмийн орчин : Улаанбаатар хотын аялал жуулчлалын бүсэд төсөл, программуудыг хэрэгжүүлсний улмаас нийгмийн хүрээнд томоохон сөрөг нөлөө үзүүлэх байдал ажиглагдахгүй байна. Санал болгож байгаа төсөл, хөтөлбөрүүд нь аялал жуулчлалын салбарын хувьд нийгэм– эдийн засгийн үлэмж хэмжээний үр ашиг өгөхийн зэрэгцээгээр Улаанбаатар хотын оршин суугчдад ч гэсэн бүхэлдээ ашиг тустай арга хэмжээ болно. Гэхдээ аялалын гол зам харгуй, томоохон музейн орчимд жуулчны оргил ачааллын улиралд ирж очих хүмүүс, машин тэрэгний тоо нэмэгдсэнээс нийгмийн амьдралд зохисгүй нөлөөлөл үзүүлж болзошгүйг анхааран үүнийг арилгах тодорхой арга хэмжээнүүдийг тусгасан менежментийн программ хэрэгжүүлэх нь зүйтэй.

Улаанбаатар хотын орчинд хэрэгжүүлэхээр санал болгож буй төсөл, хөтөлбөрүүдийн орчны шалгуур

Хугацаа	Төсөл, хөтөлбөрүүдийн нэр	НҮ
2005 он хүр тэлх ойрын хугацаанд	Холбогдох дэд бүтцийг хөгжүүлэх 1) Тэрэлжийн Зочдыг хүлээн авах төв	○
2005 оноос цааших дунд болон урт хуга цаанд	Аялал жуулчлалын материаллаг баазыг хөгжүүлэх 1) Улаанбаатар хотын оршин суугчдад зориулан гольфын талбай байгуулах	○
	2) Улаанбаатар хотын оршин суугчдад зориулан цанын амралтын газар байгуулах Улаанбаатарын ойролцоо	○
	Холбогдох дэд бүтцийг хөгжүүлэх 1) Улаанбаатар хотын онгоцны буудлыг сайжруулах/ Улаанбаатарт шинэ онгоцны буудал барих (2010 оноос хойш)	○
	2) Автозамуудыг сайжруулах	○

Тайлбар: НҮ= Нарийвчилсан үнэлгээ; Орчны анхдагч үнэлгээ хийх шаардлагатай.
Эх сурвалж: ЖАЙКА– гийн Судалгааны баг

Өмнөговийн аялал жуулчлалын бүс нутаг

- 1) Байгаль орчин: Байгаль орчинг хамгаалах хуулийн дагуу үндэсний дархан цаазтай газруудад хэрэгжигдэх ёстой төслүүдийн байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн үнэлгээг хийсэн байх шаардлагатай. Онгоц хөөрөх буух зурвасыг сайжруулах явцад орчны хөрсийг бохирдуулах, ялангуяа шатахуун тос асгаж бохирдуулах боломж үүсч болзошгүйг харгалзан хөтөлбөрийн үндсэн төсөл боловсруулахаас өмнө сөрөг нөлөөллийг арилгах арга хэмжээнүүдийг тодорхойлсон байх ёстой
- 2) Нийгмийн орчин : Санал болгож байгаа төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх нь нутгийн аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх, нүүдэлчин ард олны аж амьдралыг дээшлүүлэхэд ихээхэн үр өгөөжтэй байх бөгөөд малчдын уламжлалт нийгэм соёлын бүтцэд томоохон сөрөг нөлөө үзүүлэхгүй гэсэн дүгнэлт гарсан юм.

Өмнөговийн бүс нутагт хэрэгжүүлэхээр санал болгож буй төсөл, хөтөлбөрүүдийн орчны шалгуур

Хугацаа	Төсөл, хөтөлбөрүүдийн нэр	НҮ
2005 он хүр тэлх ойрын хугацаанд	Аялал жуулчлалын материаллаг баазыг хөгжүүлэх	
	1) Ёлын Аман дахь говийн Зочдыг хүлээн авах төв (мэдээллийн төв)	○
	Холбогдох дэд бүтцийг хөгжүүлэх	
2005 оноос цааших дунд болон урт хугацаанд	1) Өмнөговийн онгоцны буудлын зурвасыг сайжруулах	○
	Аялал жуулчлалыг дэмжих хөтөлбөрүүд	
	1) Сэврээ (төв хэсэг) болон Говь Гурван Сай ханы дархан цаазат газрын баруун хэсгийг хөгжүүлэх	○
	Холбогдох дэд бүтцийг хөгжүүлэх	
	1) Даланзадгадын онгоцны буудлыг сайжруулах	○
2) Даланзадгад, Сэврээ болон аймгийн баруун хэсгийн хооронд агаарын тээврийг хөгжүүлэх	○	
3) Автозамыг сайжруулах (Даланзадгад– Сэврээ)	○	

Тайлбар: НҮ= Нарийвчилсан үнэлгээ; Орчны анхдагч үнэлгээ хийх шаардлагатай.
Эх сурвалж: ЖАЙКА- гийн Судалгааны баг

Хархорины аялал жуулчлалын бүс нутаг

- 1) Байгаль орчин: Аялал жуулчлалын зориулалтаар барьж байгуулах зам нь түүний байршил, чиглэл, хэмжээнээс шалтгаалан хөрсний гадаргууг элээх, бүрэлдэн тогтсон эко–системийг эвдэж сүйтгэх зэргээр байгаль орчинд нөлөөлөх нь тодорхой. Санал болгож байгаа газар нутаг, замууд нь чийг намагтай, зэрлэг шувууд олноор ирж нутагшдаг газрыг хөндөж байгаа учир зам барилгын ажлын үндсэн зураг төсөл боловсруулах шатанд дээрх сөрөг нөлөөллийг арилгах тодорхой арга хэмжээнүүдийг нарийвчлан боловсруулж байгаль орчны үнэлгээ явуулах хэрэгтэй байна. Хархорины онгоцны буудлыг сайжруулах ажил нь түүний цар хүрээнээс хамааран хөрсний гадаргууг эвдэх, шатахуун тосоор бохирдуулах, хүмүүсийг олноор бөөгнөрүүлэх зэрэг зохисгүй үр дагавартай байж болох талтай. Тийм учраас мөн адил гарч болох сөрөг нөлөөллийг нарийвчлан тодорхойлж урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүдийг

төлөвлөж хэрэгжүүлсэн байх ёстой. Газрын хөрсийг ухаж эрдэм шинжилгээний судалгаа явуулахдаа юуны өмнө үүнээс болж хөрсний эвдрэл үүсэхгүй байх талаас нь асуудалд хандаж хамгийн зохистой менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх нь зүйтэй.

- 2) Нийгмийн орчин : Санал болгож байгаа төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх нь Хархорины аялал жуулчлалын бүс нутагт орших сумдын төв, тэндхийн айлуудад ямарваа нэгэн нийгмийн сөрөг нөлөө үзүүлэхгүйгээр үл барам нийгэм – эдийн засгийн үлэмж хэмжээний үр ашигтай байх болно.

Хархорины бүс нутагт хэрэгжүүлэхээр санал болгож буй төсөл, хөтөлбөрүүдийн орчны шалгуур

Хугацаа	Төсөл, хөтөлбөрүүдийн нэр	НҮ
2005 он хүр тэлх ойрын хугацаанд	Холбогдох дэд бүтцийг хөгжүүлэх	
	1) Хархорины жуулчдын замууд (Уйгарын хэрэм хүртэлх)	○
	2) Хархорины жуулчдын замууд (Түргийн хөшөө хүртэлх)	○
2005 оноос цаашир дунд болон урт хугацаанд	Холбогдох дэд бүтцийг хөгжүүлэх	
	1) Хархорины жуулчдын замууд (Бусад замууд)	○
	2) Хархорины онгоцны буудлыг сайжруулах	○

Тайлбар: НҮ= Нарийвчилсан үнэлгээ; Орчны анхдагч үнэлгээ хийх шаардлагатай.
Эх сурвалж: ЖАЙКА-гийн Судалгааны баг

7.4 Орчны хүчин зүйлс

1) Байгаль орчны хүчин зүйлс

Монгол орны байгалийн нэг чухал онцлог шинж нь түүний эко–систем маш хэврэг байгаад оршино. Тун бага хэмжээний хур тунадас орох учир газрын гадаргуу болон ус, хөрсний бохирдол арилж үгүй болох боломж ихээхэн бага байна. Түүнчлэн, бүхэл жилийн турш агаарын температур бага байдаг тул ямарваа нэгэн бохирдлыг арилгаж цэвэршүүлдэг байгалийн биологийн явц явагдахгүй шахам юм. Мөн ургамал, амьтны нөхөн төлжилт ихээхэн удаашралтай байгаагаас биологийн төвлөрөл, идэвхижил үндсэндээ зогсонги талдаа бөгөөд мөнх цэвдэг нь бохирдлыг газрын хөрснөөс доошхи гүн рүү тарж шингэх боломж олгохгүй байна. Иймээс байгаль орчны хувьд хүний үйл ажиллагааны үр дүнд бий болох нэмэлт ачаалал нь үндсэндээ тухайн газар нутаг дээрээ бөөгнөрөн хадгалагдаж байгаль орчинд төдийгүй хүний ахуй амьдралд ихээхэн хүчтэй сөрөг нөлөө үзүүлэх нь тодорхой.

Монгол орны нэгж нутаг дэвсгэрт ногдох байгаль орчны багтаамж маш бага учраас байгаль орчныг хамгаалах үндсэн шаардлагуудыг бүрэн хяналтандаа авч чадаагүй нөхцөлд аялал жуулчлалыг хөгжүүлэх үйл ажиллагааг нэг дор нэг тодорхой бүс нутагт бөөгнөөрүүлж болохгүй.

Жуулчдын үйлчилгээнд шаардагдах түлшний модны хэрэгцээ нь орон нутгийн хэрэглээтэй харьцуулахад бага хэдий боловч ирээдүйд барагцаалбал 10 дахин өсөх хандлагатай байна. Байгаль орчныг хамгаалах, ялангуяа ой мод устаж үгүй болох явдлаас сэргийлэх зорилгоор аргал түлшинд хэрэглэхийг дэмжих нь зүйтэй. Түүгээр ч зогсохгүй Ой мод хамгаалах хуулийг хүчтэй болгох, ойн хяналт бүхий газруудыг хөгжүүлэх хэрэгтэй байна.

2) Нийгмийн орчин дахь шалгуур

- (1) Аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар нүүдэлчин малчдын санал: Олон нийтийн судалгааны үр дүнгээс харахад тэргүүлэх чиглэлийн бүс нутагт байгаа бараг бүх нүүдэлчин малчид аялал жуулчлалыг хөгжүүлэх арга хэмжээнүүдийг бүхэлд нь дэмжиж аялал жуулчлалын хөгжлөөс нааштай үр дүн (ялангуяа, ажлын байр бий болгох утгаар нь) хүлээж байгаагаа илэрхийлсэн байна.
- (2) Аялал жуулчлалын салбарын үйл ажиллагаанд нүүдэлчин малчдаас оролцох тухай: Ажилгүй байгаа олон хүмүүс, ялангуяа залуучууд, аялал жуулчлалын салбарт ажиллах сонирхолтой байгаагаа илэрхийлсэн бөгөөд тэд энэ чиглэлийн мэргэжлийн сургалтанд хамрагдахыг хүссэн болно. Гэвч алслагдсан бүс нутагт аялал жуулчлалын мэргэжлийн тусгай сургалт явуулах боломж ихээхэн хязгаармагдал юм.
- (3) Орон нутгийн хүмүүсийн тухайд үүсч болох асуудлууд, түүний шийдвэрлэлт: Нутгийн ихэнхи хүмүүс нийгэм- соёлын ямарваа нэгэн хүчин зүйлсийг харгалзахгүйгээр аялал жуулчлалыг хөгжүүлэх асуудлыг дэмжиж байгаа. Иймээс орон нутгийн засаг захиргаа нийгэм- соёлын болон байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг онцгойлон хянасны үндсэн дээр төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх асуудлаар төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэн ажиллах шаардлагатай.
- (4) Нүүдэлчин малчдын хувьд үүсч болох асуудлууд, түүний шийдвэрлэлт: Хэдийгээр малчид малаа хариулах явцад жуулчдын аялалын маршрут, зам харгуйн дагуу жуулчдын бөөгнөрөл хөдөлгөөн ихсэх байдалтай тулгарах боловч бидний явуулсан судалгааны үр дүнгээс үзэхэд тэд бараг бүгдээрээ үүнд төдийлэн санаа зовохгүй байгаа нь ойлгогдсон. Гэхдээ аялал жуулчлалыг хөгжүүлснээр уламжлалт мал сүргийг хариулах арчлах арга барил, мал сүрэгт сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй байх үүднээс эдгээрийг урьдчилан судалж зохицуулах шаардлагатай.
- (5) Бусад асуудлууд, түүний шийдвэрлэлт: Жуулчлалын ид ачааллын улиралд жуулчдын тоо нэмэгдэхийн хамтаар элдэв хог хаягдал болон замын хөдөлгөөн жуулчлалын гол газруудад огцом ихсэх таагүй байдал гарах нь мэдээж. Иймээс ариун цэврийг сахих, орчныг тохижуулах, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үүднээс хог хаягдлыг арилгах арга хэмжээнүүдийг төсөл, хөтөлбөрүүдийн нэг хэсэг болгон орон нутгийн хүмүүс, гадаадын жуулчдыг оролцоотойгоор хэрэгжүүлэх шаардлагатай.





